



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хануй голын газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

 БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Анхдагчдын өргөн чөлөө 1-120, Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082 Утас/Факс: 7034-3259 E-mail: bulgan@audit.gov.mn	ХАНУЙ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Д.БЯМБАЖАРГАЛ ТАНАА
2022.02.25 № 45	
танай _____ ны № _____ т	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хануй голын сав газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Хануй голын сав газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p> <p>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</p> <p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх</p>	
<small>D:/bichighereg/2022A4toot</small>	
006020029	

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,186,534.00</u>	<u>26,579,074.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	9,186,534.00	26,579,074.00
351	Түүхий эд материал	6,348,000.00	21,269,000.00
35110	Тусгай зориулалттай материал	6,348,000.00	21,269,000.00
354	Хангамжийн материал	2,838,534.00	5,310,074.00
35410	Бичиг хэргийн материал	114,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	2,724,534.00	4,344,534.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	527,540.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	438,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,262,893.69</u>	<u>16,269,226.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,262,893.69	16,269,226.89
392	Биет хөрөнгө	19,262,893.69	16,044,643.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,297,500.00	21,297,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,727,680.44	-13,602,347.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,488,920.00	18,517,090.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,626,253.12	-11,481,926.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,160,798.84	5,160,798.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,330,391.59	-3,846,471.39
393	Биет бус хөрөнгө	00.00	224,583.30
39301	Програм хангамж	00.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-160,416.70
39303	Бусад биет бус хөрөнгө	770,000.00	00.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>28,449,427.69</u>	<u>42,848,300.89</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>28,449,427.69</u>	<u>42,848,300.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	28,449,427.69	42,848,300.89
512	Хуримтлагдсан үр дүн	28,449,427.69	42,848,300.89
51210	Өмнөх үеийн үр дүн	28,449,427.69	28,449,427.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	14,398,873.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>28,449,427.69</u>	<u>42,848,300.89</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	118,814,786.00	152,319,558.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,950,500.00	21,806,783.76
120	Нийтлэг татварын бус орлого	1,950,500.00	21,806,783.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,950,500.00	21,806,783.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,950,500.00	21,806,783.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,864,286.00	130,512,775.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	110,650,000.00	92,890,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	110,650,000.00	92,890,100.00

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,214,286.00	37,622,675.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,500,000.00	22,701,675.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	14,921,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	122,329,129.09	137,920,685.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,329,129.09	137,920,685.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,013,209.16	137,085,761.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,405,355.00	61,424,600.00
210101	Үндсэн цалин	43,615,510.56	51,420,100.00
210102	Нэмэгдэл	7,682,083.80	5,606,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,107,760.64	4,397,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,858,367.57	9,360,575.68
210201	Тэтгэврийн даатгал	6,361,667.57	6,864,175.68
210202	Тэтгэмжийн даатгал	624,200.00	624,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	499,300.00	499,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	124,900.00	124,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,248,300.00	1,248,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,800,000.00	3,250,000.00
210304	Байрны түрээс	2,800,000.00	3,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,820,577.50	18,225,835.00
210401	Бичиг хэрэг	587,850.00	909,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,584,720.00	14,967,435.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,677.50	1,260,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	665,330.00	1,088,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,219,432.00	1,286,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	850,000.00	540,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	199,932.00	178,200.00
210604	Урсгал засвар	1,169,500.00	568,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,171,700.00	6,090,000.00
210702	Дотоод албан томилолт	3,171,700.00	6,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,692,100.00	27,569,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	26,891,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	131,400.00	157,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	54,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	382,000.00	466,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,045,677.09	9,879,450.56
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,045,677.09	9,879,450.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,315,919.93	834,924.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,200,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,105,339.93	834,924.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,105,339.93	834,924.32

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,580.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,580.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,514,343.09	14,398,873.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,514,343.09	14,398,873.20

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	28,449,427.69	28,449,427.69
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	28,449,427.69	28,449,427.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	28,449,427.69	28,449,427.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,398,873.20	14,398,873.20
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	42,848,300.89	42,848,300.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	116,864,286.00	130,512,775.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,864,286.00	130,512,775.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	110,650,000.00	92,890,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	110,650,000.00	92,890,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,214,286.00	37,622,675.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,500,000.00	22,701,675.00

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	14,921,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	116,864,286.00	130,512,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,864,286.00	130,512,775.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,548,366.07	129,677,850.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,405,355.00	61,424,600.00
210101	Үндсэн цалин	43,615,510.56	51,420,100.00
210102	Нэмэгдэл	7,682,083.80	5,606,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,107,760.64	4,397,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,858,367.57	9,360,575.68
210201	Тэтгэврийн даатгал	6,361,667.57	6,864,175.68
210202	Тэтгэмжийн даатгал	624,200.00	624,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	499,300.00	499,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	124,900.00	124,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,248,300.00	1,248,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,800,000.00	3,250,000.00
210304	Байрны түрээс	2,800,000.00	3,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,884,577.50	19,959,375.00
210401	Бичиг хэрэг	651,850.00	795,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,584,720.00	15,494,975.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,677.50	1,260,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	665,330.00	2,408,400.00
2105	Нормативт зардал	438,600.00	438,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	438,600.00	438,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,297,666.00	1,586,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	850,000.00	540,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	278,166.00	178,200.00
210604	Урсгал засвар	1,169,500.00	868,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,171,700.00	6,090,000.00
210702	Дотоод албан томилолт	3,171,700.00	6,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,692,100.00	27,569,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	26,891,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	131,400.00	142,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	54,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	14,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	382,000.00	466,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,315,919.93	834,924.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,200,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,105,339.93	834,924.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,105,339.93	834,924.32
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,580.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,580.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,890,100.00	92,055,175.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,890,100.00	92,055,175.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,890,100.00	92,055,175.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,424,600.00	61,424,600.00
210101	Үндсэн цалин	51,420,100.00	51,420,100.00
210102	Нэмэгдэл	5,606,900.00	5,606,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,397,600.00	4,397,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,412,600.00	9,360,575.68
210201	Тэтгэврийн даатгал	6,916,200.00	6,864,175.68
210202	Тэтгэмжийн даатгал	624,100.00	624,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	499,300.00	499,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	124,800.00	124,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,248,200.00	1,248,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,282,500.00	3,250,000.00
210304	Байрны түрээс	3,282,500.00	3,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,453,700.00	5,453,700.00
210401	Бичиг хэрэг	371,700.00	371,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.00	3,213,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,300.00	1,260,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	608,400.00	608,400.00
2105	Нормативт зардал	438,600.00	438,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	438,600.00	438,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	546,200.00	546,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,200.00
210604	Урсгал засвар	368,000.00	368,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,738,000.00	1,994,000.00
210702	Дотоод албан томилолт	2,738,000.00	1,994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,593,900.00	9,588,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,910,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	142,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,400.00	54,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	466,000.00	466,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,890,100.00	92,890,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	92,890,100.00	92,890,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	92,890,100.00	92,890,100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	06.00	06.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	05.00	05.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,622,675.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,622,675.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,622,675.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,505,675.00
210401	Бичиг хэрэг	424,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,281,675.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,040,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	540,000.00
210604	Урсгал засвар	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,096,000.00
210702	Дотоод албан томилолт	4,096,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,981,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,981,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37622675.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,622,675.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,701,675.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,921,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хануй голын сав газрын захиргаа нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7-дугаар сарын 25-ны өдрийн Сав газрын захиргааны талаар авах арга хэмжээний тухай 254 дүгээр тогтоол, БОНХөгжлийн сайдын 2014 оны 1-дүгээр сарын 24-ний өдрийн “Хануй голын сав газрын захиргааны бүтэц, орон тоо, дүрэм батлах тухай” А-25 дугаар тушаалаар байгуулагдсан. Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

Булган аймгийн Баян-Агт сумын унд ахуйн зориулалтаар ашигладаг 8 худагт эрүүл ахуйн бүс тогтоосон эсэхэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан.

- Сумын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох ИТХ-ын тогтоол гараагүй боловч 4-н ус хангамжийн эх үүсвэрийг хашаажуулсан.

Булган аймаг Булган сумын 1, 3, 6 дугаар багийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 8 ус түгээх байранд эрүүл ахуйн бүсэд хяналт шалгалт хийж, ундны усны эрүүл ахуйн талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж тараах материалыг мэдээллийн самбарт байршуулсан.

Сав газарт хамрагдах 4 сумын Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт Ус хангамжийн эх үүсвэрийн худгуудад эрүүл ахуйн бүс, усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн энгийн болон онцгой хамгаалалтын бүс тогтоосон болон тогтоох тухай 2021 оны №70, 72 тоот албан бичгийг хүргүүлсэн.

2021 оны №120 тоот албан бичгээр хяналт шалгалтаар гарсан зөрчил дутагдлыг арилгуулах тухай зөвлөмжийг сав газарт хамрагдах 4 сумын Засаг дарга нарт хүргүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 92,890.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 928.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 650.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,420.4 мянган төгрөгөөр буюу 0.24 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Бараа материал	9,186.53	26,579.10	17,392.54
Үндсэн хөрөнгө	19,262.90	16,269.23	(2,993.67)
Нийт хөрөнгө	28,449.43	42,848.30	14,398.87
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	28,449.43	42,848.30	14,398.87
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	28,449.43	42,848.30	14,398.87

Бараа материалын данс 26,579.10 мянган төгрөг болж 17,392.54 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дээр Байгаль орчин , аялал жуулчлалын сайдын 2021 оны 10-р сарын 06-ний өдрийн А/314 тоот тушаалын дагуу Хануй голын зарим рашаануудыг хашиж хамгаалах ажлын 14,921.0 мянган төгрөг нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэлд 20 нэр төрлийн 45,360.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. 2021 оны санхүүгийн тайланд 2,076.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй нэг бүрийн үнэ нь 1,705.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 суурийн /Dell/ компьютерийг ТӨБЗГазрын 2021 оны 07 сарын 02-ны өрийн А-1/1154 тоот тогтоолын Усны газраас балансаас балансад шилжүүлэн шийдвэр , Хануй голын сав газрын захиргааны өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 09 сарын 02-ны өдрийн №4 тоот шийдвэр, 2021 оны 09 сарын 03-ны өдрийн А/18 тоот Байгууллагын даргын тушаалаар тус тус үндэслэн бүртгэв. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 01-р сарын 12-ны өдрийн 07 тоот тогтоол, Байгууллагын даргын 2021 оны 03-р сарын 29-ны өдрийн А/10

тоот тушаалыг үндэслэн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үлдэх өртөггүй ашиглах хугацаа нь нь дууссан 7-н нэр төрлийн 13,318.90 үнэ бүхий 12 үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг 1 жилээр сунгаж үнийг / 5,552.09 / шинэлэн тогтоож бүртгэснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 42,848.3 мянган төгрөг болж 14,398.87 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 33,504.77 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар, нийт зардал өмнөх оноос 165 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 119,065.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 119,065.9 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 26,175.8 мянган төгрөгөөр бууруулан 92,890.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 92,890.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт санхүүжилтээр 37,622.67 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 129,677.85 мянган төгрөгийг зарцуулж, 834.92 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 834.92 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 52.02 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 32.5 мянган төгрөг, дотоод албан томилолтоос зардлыг 744.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгаль орчин , аялал жуулчлалын сайдын 2021 оны 10-р сарын 06-ний өдрийн А/314 тоот тушаалын дагуу Хануй голын зарим рашаануудыг хашиж хамгаалах ажлын хүрээнд дээд шатны төсвийн захирагчаас 14,921.0 мянга , Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс /Байгаль хамгаалах сангаас / “ Усны тоо бүртгэл явуулах “ 16,031.6 мянган төгрөг, Рашааны шинжилгээнд хамруулах зардалд 6,670.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

Үүнээс тээвэр шатахууны зардал 12,281.6 мянган төгрөг, Бичиг хэргийн зардалд 424.0 мянган төгрөг ,БҮТЭЗ-н зардалд 1,800.0 мянган төгрөг, Багаж техник, хэрэгслийн зардалд 540.0 мянган төгрөг , Урсгал засварт 500.0 мянган төгрөг, Албан томилолтын зардалд 4096.0 мянган төгрөг тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Хануй голын сав газрын захиргааны нь 2021 онд нийт 1,202,496.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 322.6 мянган 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-

Зөвлөмж	2	322.6	2	322.6	-	-	-
Нийт дүн	2	322.6	2	322.6	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар тухайн байгууллагад алдаа зөрчил илрээгүй болно.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР